



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/64

Жаргалтхаан

Хорио цээрийн дэглэм тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.3, 20 дугаар зүйлийн 20.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Гичгэнэ багийн нутаг “Зүлэгт” гэх газар нутаглаж буй малчин Г.Мөнхзоригийн хонинд малын гоц халдварт хонины цэцэг өвчнөөр өвчилсөн болох нь Хэнтий аймгийн Мал эмнэлгийн лабораторийн 24-128 дугаартай шинжилгээний хариугаар баталгаажсан тул дээрх бүс нутагт 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн хорио цээрийн дэглэмийг тогтоосугай.

2. Хорио цээрийн дэглэмийг “Зүлэгт” гэх газраас гадагш 10 километрийн тойрогт тогтоосугай.

3. Хорио цээрийн дэглэм тогтоосон зураглалыг 1 дүгээр хавсралтаар, мэргэжлийн багийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд нутаглаж буй малчдын суурьт үзлэг, ариутгал, халдваргүйжүүлэлт хийж, холбогдох заавар, зөвлөмжийн дагуу урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд даалгасугай.

5. Халдвар тархахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ажлыг шуурхай хэрэгжүүлж, хорио цээрийн дэглэм тогтоосон бүсэд мөрдөж ажиллах заавар журмыг чанд сахиулж, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (С.Жавзандулам)-д, голомтын болон сэжигтэй бүсэд байгаа мал сүргээ байнгын хариулга, маллагаатай байлгаж, хорио цээрийн дэглэмийг чанд мөрдөж ажиллахыг нийт малчдад, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Багийн засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

232401151

2.


6. Хорио цээрийн дэглэмийн бүсэд ариутгал халдваргүйтгэл, хяналтын цэг ажиллуулах, хуваарийн дагуу хүн хүчийг дайчлах, шаардагдах зардлын тооцоог гаргах, захирамжийн хэрэгжилтийг хангуулж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (С.Мөнхдэлгэр)-т даалгасугай.

ДАРГА



Л.ЦЭНГЭЛ

Сумын Засаг даргын 20²⁴ оны
04 дүгээр сарын 29-ны өдрийн
А/64 тоот захирамжийн 2-р хавсралт



Хорио цээрийн дэглэмийн үед
ажиллах мэргэжлийн баг

1. Багийн ахлагч:

Засаг даргын Тамгын газрын дарга - С.Мөнхдэлгэр

2. Нарийн бичгийн дарга:

Мал эмнэлгийн тасгийн дарга - С.Жавзандулам

3. Гишүүд:

Гичгэнэ багийн Засаг дарга – Д.Энхболд

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн – Г.Мөнхсайхан

Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн – Г.Түмэнжаргал

Эрэн хайх, аврах бүлгийн дарга – Б.Болор-Эрдэнэ

Мөнхбадрах Зоргол ХХК-ийн Малын эмч – Б.Уранцэцэг

Мэргэн Жонон ХХК-ийн Малын эмч – Ц.Ганбат, Г.Сугар

Таван эрдэнэ сүрэг ХХК-ийн Малын эмч – П.Жамбалдорж